













АГУУЛГА

		Хуудас
	ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	2
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
	ДҮҮРГИЙН ТӨСӨВ	7
	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	9
	БАЙГАЛЬ ОРЧИН, ТОХИЖИЛТ	9
	ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	10
	НИЙГМИЙН ДАА ТГАЛ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	11
	СПОРТ, СОЁЛ УРЛАГ	14
	АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО	15
	АЖ ҮЙЛДВЭР	16
	ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	17
	ОСОЛ, ГЭМТ ХЭРЭГ	20



ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн үндсэн үзүүлэлт, 2015 оны 4 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 он	2015 он
Суурин хүн ам /жилийн эцэст/	Хүн	155859	159514
Төрөлт	Тоо	1424	1541
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	1431	1556
Нас баралт	Тоо	303	263
Халдварт өвчин	Тоо	714	781
Ажилгүйчүүд	Хүн	1857	2622
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	811	869
Дүүргийн төсвийн орлого	Сая төгрөг	17837.4	19292.8
Дүүргийн төсвийн зарлага	Сая төгрөг	13463.3	16708.1
Валютын ханш	1US\$=₮	1796	1960

Хүснэгт 2. Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо

Хороо	2012 он		2013 он		2014 он	
	Хорооны нийт талбай /га/	Хүн ам	Хорооны нийт талбай /га/	Хүн ам	Хорооны нийт талбай /га/	Хүн ам
1	29.7	3213	29.7	3683	29.7	3750
2	19.7	3098	19.7	3191	19.7	3354
3	16.5	5013	16.5	5689	16.5	5793
4	30.6	5334	30.6	5211	30.6	5282
5	28.2	5678	28.2	4422	28.2	4918
6	24.6	6359	24.6	6278	24.6	6718
7	47.2	13105	47.2	13129	47.2	13657
8	45.1	5116	45.1	4911	45.1	4994
9	71.8	7963	71.8	7574	71.8	7906
10	47.3	7340	47.3	8411	47.3	8306
11	158.1	6621	158.1	6227	158.1	6185
12	317.2	13997	317.2	15018	317.2	15647
13	94.9	8549	94.9	8955	94.9	8624
14	93.2	8174	93.2	8104	93.2	8202
15	98.2	8681	98.2	8918	98.2	9135
16	452	11504	452	11923	452	12210
17	709.2	13375	709.2	13574	709.2	14043
18	640.2	9907	640.2	9964	640.2	9864
19	6006	9906	6006	10677	6006	10926
Нийт	8930	153933	8930	155859	8930	159514

Хүснэгт 4. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд дүүргээр

	Хэмжих нэгж	2014 оны 4 сарын байдлаар				2015 оны 4 сарын байдлаар					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /1 кв км-т ногдох хүн/	тоо	272	Баянгол	6843	Налайх	49	282	Баянгол	7158	Налайх	51
			Чингэлтэй	1761	Багануур	45		Чингэлтэй	1804	Багануур	46
			Сүхбаатар	645	Багахангай	27		Сүхбаатар	661	Багахангай	28
Ажилгүйчүүд /хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох/	0\000**	143	Налайх	494	Сонгинохайрхан	120	159	Налайх	501	Баянгол	154
			Багахангай	360	Баянзүрх	116		Багахангай	377	Баянзүрх	113
			Багануур	179	Баянгол	110		Багануур	255	Сонгинохайрхан	98
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	16	Багахангай	95	Хан-Уул	13	15	Сонгинохайрхан	14	Хан-Уул	10
			Налайх	20	Баянгол	11		Баянзүрх	14	Баянгол	6
			Багануур	18	Сүхбаатар	9		Сүхбаатар	14	Багахангай	-
Халдварт өвчнөөр өвчлөгсөд /10000 хүн тутмаас/	0\000	46	Налайх	64	Сонгинохайрхан	29	56	Налайх	95	Хан-Уул	41
			Багануур	47	Баянгол	28		Багануур	92	Баянгол	35
			Чингэлтэй	46	Багахангай	11		Баянзүрх	55	Багахангай	23
Төсвийн орлого, зарлагын харьцаа Зарлага=100	мян.төг	152	Сүхбаатар	152	Багануур	98	116	Сүхбаатар	141	Багануур	84
			Чингэлтэй	142	Налайх	80		Чингэлтэй	128	Налайх	78
			Баянзүрх	127	Багахангай	43		Хан-Уул	124	Багахангай	49
Гэмт хэрэг /18-аас дээш насны 10000 хүнд ногдох/	тоо	65	Сүхбаатар	94	Сонгинохайрхан	54	75	Сүхбаатар	125	Багануур	52
			Чингэлтэй	75	Багануур	45		Баянзүрх	81	Хан-Уул	50
			Баянзүрх	65	Багахангай	24		Чингэлтэй	79	Багахангай	27

Тайлбар: * - промилль ** - продицимил




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2015 оны 4-р сарын хэрэглээний үнийн индекс 2014 оны мөн үетэй харьцуулахад 8.7 хувь, өмнөх сартай харьцуулахад 0.8 хувиар тус тус өссөн.

Хүснэгт 5. Хэрэглээний үнийн индекс

Бараа үйлчилгээний бүлэг	Жин	<u>2015.04</u> <u>2014.04</u>	<u>2015.04</u> <u>2015.03</u>
Ерөнхий индекс	100.0	108.7	100.8
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	105.0	102.8
Согтууруулах ундаа, тамхи	3.2	106.7	100.2
Хувцас, бөс бараа	8.5	108.3	100.2
Орон сууц, ус, түлш, цахилгаан	12.0	118.6	99.6
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	104.1	100.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	112.4	100.5
Тээвэр	7.3	107.0	100.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.7	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	2.8	111.3	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	117.2	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	104.2	100.1
Бусад бараа, үйлчилгээ	4.1	105.1	100.1

Зураг 1. Хэрэглээний үнийн өсөлт сараар



Хэрэглээний үнийн индекс 2015 оны 4-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 5.0 хувь, согтууруулах ундаа, тамхи 6.7 хувь, хувцас, бөс бараа, гутал 8.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлш 18.6 хувь, гэр ахуйн бараа, тавилга 4.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 12.4 хувь, тээврийн үйлчилгээ 7.0 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 11.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 4.2 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 5.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.


Хүснэгт 6. Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ, төгрөг / 4 сар/

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2015
Алтан тариа 1-р зэрэг	кг	640	890	810	1000	1150	1033
Атар талх	ш	610	650	650	800	900	1100
Цагаан будаа	кг	1500	1650	1650	1650	2300	2200
Шар будаа	кг	1000	1500	1550	1550	1550	1750
Хонины мах	кг	4500	4000	7500	8000	8000	7767
Үхрийн мах	кг	5000	4500	7800	9500	10500	8267
Адууны мах	кг	2500	3600	5800	6300	6500	6100
Тахианы гуя	кг	4200	4000	4000	5500	5500	6667
Сүү задгай	л	1000	1000	1100	1000	1300	1300
Хорхой ааруул	кг	4500	8000	8000	7000	9000	9667
Өндөг	ш	200	210	250	300	350	300
Ургамлын тос	л	2600	2700	2800	3000	3000	3233
Алим, кг	кг	2000	2500	3500	3500	3500	4333
Банан, шар	кг	3500	3500	3500	4000	4000	5500
Төмс	кг	800	1000	1000	1000	800	1233
Лууван	кг	800	900	1000	1100	1300	1300
Сонгино	кг	1200	1000	1000	1300	1300	1000
Элсэн чихэр	кг	1800	1600	1500	1550	1900	1800
Цэвэр усны үнэ тоолуургүй 1хүний	хүн	2307.7	3201.6	3201.6	3201.6	3201.6	4705.8
Эдийн саван ОК	ш	350	400	450	550	500	583
Угаалгын нунтаг "ОМО"	ш	500	580	580	650	650	833
Аяга, таваг угаагч шингэн, "Fairy"	ш	2500	2700	2750	3000	3290	4067


Зураг 2. Алтан тариа дээд гурил, атар талхны үнэ, 2010-2015 он




Зураг 3. Нэг кг хонь, үхрийн махны дундаж үнэ, 2010-2015 он



Зураг 4. Нэг кг лууван, төмсний дундаж үнэ, 2010-2015 он



Зураг 5. Нэг кг сонгино, байцааны дундаж үнэ, 2010-2015 он



Зураг 6. Шатахууны үнэ, 2010-2015 он






ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого: Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2015 оны 4-р сарын байдлаар 19292.8 сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүн 16708.1 сая төгрөг болж, орон нутгийн төсвийн нийт тэнцэл 2584.7 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан.

Зураг 7. Төсвийн урсгал орлого




2015 оны 4-р сарын байдлаар орон нутгийн нийт төсвийн төлөвлөгөөний биелэлтийг нэр тус бүрээр нь доорх хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 7. Төсвийн урсгал орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт орлогын дүн	17466468.8	19292838.8	1826370.0	10.5
Урсгал орлого	6693885.0	8572601.5	1878716.5	28.1
1.Татварын орлого	6090360.0	8222612.4	2132252.4	35.0
Орлогын албан татвар	2596073.0	4255862.5	1659789.5	63.9
Өмчийн татвар	2137.0	2731.0	594.0	27.8
Бусад татвар	3492150.0	3964018.9	471868.9	13.5
2.Татварын бус орлого	603525.0	349989.1	-253535.9	42.0
Тусламжийн орлого	10772583.8	10720237.3	-52346.5	0.5

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 2015 оны 4-р сарын байдлаар 16708.1 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 4896.1 сая төгрөг төсвийн зардлыг хэмнэсэн байна.

Зураг 8. Төсвийн урсгал зарлага



Төсвийн нийт зарлагын 37.2 хувийг цалин хөлс, 4.2 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 44.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 9.8 хувийг татаас, 4.6 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 8. Төсвийн зарлага

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	21604275.7	16708136.3	-4896139.4	22.7
А. Урсгал зардлын дүн	18393557.9	15932911.7	-2460646.2	13.4
1. Баргаа үйлчилгээний зардал	16761657.9	14301011.7	-2460646.2	14.7
1.1 Цалин хөлс	6494897.9	6214205.9	-280692.0	4.3
1.2 НДШ хураамж	746772.2	708926.4	-37845.8	5.1
1.3 Баргаа үйлчилгээний бусад зардал	9519987.8	7377879.4	-2142108.4	22.5
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	1631900.0	1631900.0	0.0	-
3.1 Татаас	1631900.0	1631900.0	0.0	-
3.2 Урсгал шилжүүлэг	0.0	0.0	0.0	-
Б. Хөрөнгийн зардал	3210717.8	775224.6	-2435493.2	75.9
1. Хөрөнгө оруулалт	3210717.8	775224.6	-2435493.2	75.9


2015 оны 4-р сарын байдлаар орон нутгийн нийт өглөг сарын эхэнд 69.0 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 35.4 сая төгрөгийн өглөг үүсч, 59.0 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, 45.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Орон нутгийн төсвийн авлага 2.3 сая төгрөгийн авлагатай гарсан байна.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны 4 дугаар сарын мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй 2622 иргэн бүртгүүлсэн байна. Нийт ажил хайж байгаа эмэгтэйчүүд 1441 буюу 54.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 40 буюу 1.5 хувь байна.

Зураг 9. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр



Насны бүлгээр авч үзвэл нийт ажил хайж байгаа иргэдийн 393 буюу 15.1 хувь нь 15-24 насны, 1057 буюу 40.3 хувь нь 25-34 насны, 601 буюу 22.9 хувь нь 35-44 насны, 444 буюу 16.9 хувь нь 45-54 насны, 127 буюу 4.8 хувь нь 55, түүнээс дээш насны хүмүүс байна.



БАЙГАЛЬ ОРЧИН, ТОХИЖИЛТ

ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ:

2015 оны 3-р сарын байдлаар 3286.2 мян.м/кв зам талбай цэвэрлэж, 34.1 мян.м/куб хог тээвэрлэсэн байна. Ажил үйлчилгээний орлого 1578.4 сая төгрөг болсон байна. Орлогын эх үүсвэрийг ангилвал 17.7 хувийг зам талбай, 39.5 хувийг гэр хорооллоос, 24.6 хувийг орон сууцнаас, 18.2 хувийг албан газраас олсон орлого эзэлж байна.

Хүснэгт 9. Тохижилтын ажил

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014.04	2015.04	Зөрүү	Өсөлт, бууралт
Цэвэрлэсэн талбай	мян.м/кв	3501.2	3286.2	-215.0	6.1
Тээвэрлэсэн хог	мян.м/куб	32.8	34.1	1.3	4.0
Ажил үйлчилгээний орлого	сая төгрөг	1753.9	1578.4	-175.5	10.0

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

2015 оны 4-р сарын байдлаар Дүүргийн Засаг даргын 16 удаагийн захирамжаар иргэний ахуйн зориулалтаар газар эзэмшүүлэх эрхээ шилжүүлэх 61, газрын талбай, зориулалт, хаяг өөрчилсөн 10 иргэн, газар эзэмших эрхийн хугацаа сунгасан 5 иргэн байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2015 оны 4-р сарын байдлаар дүүргийн хэмжээнд 1541 эх амаржиж, 1556 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эхийн тоо 117 буюу 8.2 хувь, амьд төрсөн хүүхэд 125 буюу 8.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Эмнэлгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2014.04	2015.04	Хувь/%/	Зөрүү
Нийт үзлэг		257058	241676	6.0	-15382
Үүнээс:	Урьдчилан сэргийлэх	101746	90850	10.7	-10896
	Амбулаторит	73171	72300	1.2	-871
	Диспансерийн хяналт	31322	31908	1.9	586
	Гэрийн үзлэг	49004	44973	8.2	-4031
	Гэрийн дуудлагын үзлэг	1815	1645	9.4	170
Бүртгэгдсэн өвчлөл		7883	11462	45.4	3579
Үүнээс:	Шинэ	5262	7660	45.6	2398
	Хуучин	2621	3802	45.0	1181
Бүртгэгдсэн хорт хавдар		7	9	28.6	2
Осол гэмтлийн өвчлөл		334	187	44.0	-147
Хэвтсэн өвчтөн		3600	3212	10.8	-388
Эмнэлгийн нас баралт		18	12	33.3	-6
Хоног болоогүй нас баралт		9	6	33.3	-3
Түргэн тусламжийн дуудлага		2037	1255	38.4	-782

Он гарсаар 263 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 40 хүнээр буюу 13.2 хувиар буурсан байна. Нийт нас баралтын дотор нялхасын эндэгдэл 17 буюу 6.5 хувь, 1-5 насны хүүхдийн эндэгдэл он гарсаар бүртгэгдээгүй байна. Нялхасын эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 10.5 хувиар буурсан байна. 2015 оны 4 сарын байдлаар 241.7 мян.хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 15.4 мян.хүн буюу 6.0 хувиар, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний хүний тоо 3212 болж өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 10. Нийт үзлэг, төрлөөр, 2014, 2015 оны 4 сарын байдлаар



Хүснэгт 11. Халдварт өвчин

Үзүүлэлт	2014.04	2015.04	Хувь/%/	Зөрүү	
Халдварт өвчин	714	781	9.4	67	
Үүнээс:	Гепатит	22	28	27.3	6
	Цусан суулга	40	36	10.0	-4
	Сальмоннез	1	1	-	0
	Хоолны хордлого	0	0	-	0
	Менингит	0	0	-	0
	Салхин цэцэг	103	78	24.3	-25
	Гахайн хавдар	3	0	100.0	-3
	Улаан эсэргэнэ	12	7	41.7	-5
	Ёлом	1	1	-	0
	Улаан бурхан, улаанууд	0	7	0.0	7
	Бруцеллёз	0	1	0.0	1
	Гар, хөл, ам	44	46	4.5	2
	Тэмбүү	242	222	8.3	-20
	Заг хүйтэн	25	43	72.0	18
	Трихомониаз	58	33	43.1	-25
	Мөөгөнцөр	51	32	37.3	-19
	Сүрьеэ	110	148	34.5	38
	Бусад	0	0	-	0

Дүүргийн хэмжээнд 2015 оны 4 сарын байдлаар бүртгэгдсэн өвчлөл 11462 болж өнгөрсөн оны мөн үеэс 45.4 хувиар өссөн байна. Бэлгийн замын халдварт өвчин нийт халдварт өвчний 42.3 хувийг эзэлж байна. БЗХӨ өнгөрсөн оны мөн үеэс 12.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ:

2015 оны 4 дүгээр сард төсвийн 214 байгууллагын 17385 албан хаагчид, хувийн хэвшлийн 3153 аж ахуй нэгжийн 50460 албан хаагчид, сайн дурын 10321 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.

Эрүүл мэндийн даатгалд 41713 иргэн хамрагдсан. Үүнээс төр эрүүл мэндийн даатгалыг хариуцсан даатгуулагч 29893 байна.

Хүснэгт 12. Тэтгэвэр олголт

	Хүний тоо	Олгосон тэтгэмж	
		Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Өндөр настан	17990	17151.3	18473
Тахир дутуу	3895	2622.1	2786.7
Тэжээгчээ алдсан	1316	837,2	883.1
Дүн	23201	20610.6	22142.8

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

2015 оны 4 дүгээр сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 18.1 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 1.0 хувийг хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлогод тус тус хуваарилсан байна.

Хүснэгт 13. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, 2015 оны 4-р сарын байдлаар, мян.төг

Үзүүлэлт	Үнийн дүн
Нийгмийн халамжийн сангийн орлого	4042326.4
1. Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн төсвийн санхүүжилт	920153.3
a) Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	733681.8
b) Алдарт эхийн одонгийн тусламж	-
c) Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	-
d) ОНОТХҮ үйлчилгээний санхүүжилтын орлого	143825.2
e) Хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлого	42646.3
2. Нийгмийн халамжийн сан	3120600.9
a) Төсвийн санхүүжилтын орлого	3120468
b) Бусад орлого	132.9
3. Хүүгийн орлого	1572.2
Зарлагын нийт дүн	3155072.6
1. Нийгмийн халамжийн сан	2436565.5
2. Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	658808.6
3. Алдарт эхийн одонгийн тусламж	-
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	-
5. Хүнс тэжээлийн хөтөлбөр	570.0
6. ОНОТХҮ үйлчилгээ	59128.5

Нийгмийн халамжийн сан нь 2561 хүнд халамжийн тэтгэвэр, 28052 хүнд асаргааны мөнгөн тэтгэмж, 2467 хүнд ахмад настаны хөнгөлөлт тусламж, 4596 хүнд Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн мөнгөн тэтгэмжийг зарцуулсан байна.

Дүүргийн Засаг даргад ирүүлсэн өргөдлийн дагуу 18 хүнд 25'500'000 төгрөгийн халамж, дэмжлэг тусалцаа үзүүлсэн байна.

УЛААН ЗАГАЛМАЙН ЧИГЛЭЛЭЭР:

Дүүргийн “Улаан загалмайн хороо” 2015 оны 04-р сард нийт 482 хүнд 616000 төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 131 хүн, 77000 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 14. Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүн, зардалаар

№	Үзүүлэлт	2014 он 4-р сар			2015 он 4-р сар		
		Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /төгрөг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /төгрөг/
1	Халамж үйлчилгээ	6	29	327000	4	31	616000
2	Анхны тусламжийн сургалт	11	264		36	354	
3	Гамшгийн тусламж	1	12	212000	-	-	-
4	Донорын өдөрлөг	2	46		2	97	
	Дүн	20	351	539000	42	482	616000

АХМАД НАСТАН, ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ:

➤ **Дүүргийн ахмадын хорооноос**

- Дүүргийн 95-аас дээш насны 31 настанд урьдчилан сэргийлэх үзлэг, гэрийн эргэлт зохион байгууллаа
- 2015.04.06-нд асран хамгаалагчдын сургалтыг 7-12 дугаар хороонд зохион байгуулж нийт 56 ахмад настан хамрагдав.
- Ахмадын аварга шалгаруулах тэмцээн 8 төрлөөр буюу софт волейбол, ширээний шагай, хийн дасгал, цэнгээнт бүжиг, шатар, теннис, 100 буудалт даам, явган аялалын тэмцээн уралдааныг зохион байгуулсан ба давхардсан тоогоор нийт 807 ахмад настан оролцон байна

➤ **Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалалын чиглэлээр**

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулагдсан ажил	Хамрагдсан хүний тоо
1	Хүүхдийн тусламжийн 108 утас	Ирсэн дуудлагын тоо 12	36
2	Ажилласан кейс	Асран хамгаалагч тогтоолгох 4	18
		Хүүхдийн эрхийн зөрчил 5	
		Бэлгийн хүчирхийлэл 3	
		Бие махбодийн хүчирхийлэл 1	
		Хаагдсан кейсийн тоо 1	
		Асран хамгаалагч тогтоолгох 4 кейсийн 3 дээр нь шинжээчийн дүгнэлт гарган оролцсон. Хүүхдийн эрхийн зөрчлийн 5 кейс дээр нийт 9 хүүхдийн эрхийг хамгаалан ажиллаж байна.	
3	Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр	Дүүргийн 11, 13, 18 дугаар хорооны иргэдийн дунд “Ахмад залуу гэр бүлүүдийн уулзалт” зохион байгууллаа	110
4	Хүүхэд хөгжлийн чиглэлээр	03 дугаар сарын 31-ээс 4 дүгээр сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулсан Сурагчдын өөрөө удирдах байгууллагын хоорондох нөхөрсөг урлаг, спортын наадмууд амжилттай болж өнгөрлөө.	500
		Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойг угтан 04 сарын 14-ний өдөр “Дүүргийн хөгжилд хүүхэд бидний оролцоо” Чингэлтэй дүүргийн хүүхдийн чуулганыг зохион байгууллаа.	102
5	Залуучуудын хөгжлийн чиглэлээр:	Дүүргийн хороодод “гэр бүлийн хүчирхийллийн эсрэг” кино хэлэлцүүлгийг зохион байгууллаа.	52
		“Амьдрах ухааны боловсрол олгох” сургалт зохион байгуулав.	545
		Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх өсвөр насны охидын “Бид хамтдаа” дэмжих бүлгийн гишүүдийн ээлжит уулзалтыг зохион байгууллаа.	15
6	Зорилтот бүлэгт чиглэсэн :	Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй залуу ээжүүдийн “Бид хамтдаа” дэмжих бүлгийн гишүүдийн уулзалтыг зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг кино хэлэлцүүлгийг зохион байгууллаа.	20

Дүүргийн Засаг даргын 3 удаагын захирамжаар 4 хүүхдэд асран хамгаалагч, 2 удаагийн захирамжаар 2 хүнд харгалзан дэмжигч тогтоогдсон байна.



СПОРТ, СОЁЛ УРЛАГ

СОЁЛ УРЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2015 оны 4 дүгээр сард Чингэлтэй дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс:

- Соёл урлагийн арга хэмжээ 2 зохион байгуулж, 562 хүүхэд оролцсон байна
- Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 8 зохион байгуулж, 2000 гаруй хүүхэд хамрагдсан байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2015 оны 4 дүгээр сарын байдлаар Чингэлтэй дүүрэгт биеийн тамир спортын 7 арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 186 байгууллагын 16325 хүн оролцож 13.0 сая.төг зарцуулжээ.

Хүснэгт 15. Дүүрэгт зохион байгуулагдсан спортын арга хэмжээ, 2015 он

Үзүүлэлт	Гүйцэтгэсэн үйл ажиллагаа	Оролцсон байгууллага	Нийт хамрагдсан хүн		
			Үүнээс насанд хүрэгчид	Залуучууд	Өсвөр үе, бага нас
Нийтийн биеийн тамирын талаар	Бид Чингэлтэйн залуучууд явган аялал	19 хороо	30	-	-
	Бие бялдар хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил	108	14000	-	-
	Дүүргийн ахмадын дунд зохион байгуулагдсан уралдаан тэмцээн	19 хороо	1400	-	-
Спортын арга хэмжээ	Хүүхдийн спортын V их наадмын хүрээнд зохион байгуулагдсан Өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах Хөнгөн атлетикийн тэмцээн	12	-	-	15
	Хүүхдийн спортын V их наадмын хүрээнд зохион байгуулагдсан Өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн	5	-	-	140
	Хүүхдийн спортын V их наадмын хүрээнд зохион байгуулагдсан Өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах Сагсан бөмбөгийн тэмцээн	11	-	-	240
	Хүүхдийн спортын V их наадмын хүрээнд зохион байгуулагдсан Өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах Хөлбөмбөгийн тэмцээн	12	-	-	200
Сургалт семинар	-	-	-	-	-
Секц дугуйлан	Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх спортын 11 төрөл өсвөрийн шигшээ багууд	-	-	-	300



АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

2015 оны 4-р сард татварын хэлтсийн мэдээлэл боловсруулалтын санд бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 14340 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 хувиар буюу 1358 аж ахуй нэгж байгууллагаар нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагын 78.0 хувь буюу 11185 байгууллага нь ХХК байна. Оны эхнээс нийт 271 байгууллага шинээр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 16. Аж ахуй нэгж байгууллагын тоо

ААНБ-ын төрөл	ААНБ-ын хариуцлагын хэлбэр	2015.04
Аж ахуйн нэгж, байгууллага	Хувьцаат компани	9
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11185
	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагата нөхөрлөл	115
	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	85
	ХХН	30
	Хоршоо	55
	Хадгаламж зээлийн хоршоо	67
	Төрийн өмчит үйлдвэрийн газар	30
	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	7
	Салбар	725
	Төлөөлөгчийн газар	8
	Төлөөний газар	1
	Нийт	12317
	Төсөв болон Төрийн бус байгууллага	Төсөвт байгууллага
Төрийн бус байгууллага		1435
Шашны байгууллага		40
Сан		87
Олон нийтийн байгууллага		198
Нийт	2023	
Бүгд		14340



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2015 оны 4 сард 1165.1 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25.1 хувь буюу 233.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хувцас үйлдвэрлэл 207.6 хувь, хэвлэлийн үйлдвэрлэл 47.6 хувиар тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

Хүснэгт 17. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /сая.төг/

Салбар		2014.03	2015.03	Өсөлт, бууралт/%/	Зөрүү
Бүгд		931.5	1165.1	25.1%	233.6
Үүнээс:	Хувцас үйлдвэрлэл	44.6	137.2	207.6%	92.6
	Хүнс үйлдвэрлэл	92.1	87.3	-5.2%	-4.8
	Хэвлэлийн үйлдвэрлэл	283.4	418.5	47.6%	135.1
	Бусад үйлдвэрлэл	511.4	522.1	2.1%	10.7

2015 оны 4 сарын байдлаар нийт үйлдвэрлэлтийн 11.8 хувийг хувцас үйлдвэрлэл, 7.5 хувийг хүнс үйлдвэрлэл, 35.9 хувийг хэвлэлийн үйлдвэрлэл, 44.8 хувийг боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл эзэлж байна

Зураг 11. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн





ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2015 оны 4-р сарын байдлаар иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээг 13877 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 18. Иргэний бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт		2014.02	2015.02
Нийт		11156	13877
Шинэ төрсөн		1497	1388
Гэрлэлт		273	270
Гэр бүл цуцлалт		88	93
Хүүхэд үрчлэлт		18	29
Эцэг тогтоосон		697	631
Овог, нэр өөрчлөх		54	91
Иргэний үнэмлэх олголт	16 нас хүрч шинээр авсан	688	652
	дахин олголт	1844	3317
Шилжилт хөдөлгөөн	шилжин ирсэн	2701	3338
	шилжин явсан	3296	4068

ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2015 оны 4-р сарын байдлаар эд хөрөнгийн бүртгэлийн 6 төрлийн үйлчилгээг 7926 иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлсэн байна.

Хүснэгт 19. Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт 2014.01	Үйлчлүүлсэн тоо			Үйлчилгээний хөлс		
	Нийт	Газар	Барилга, обект	Нийт	Газар	Барилга, обект
Нийт	7926	3184	4742	122530102	18309803	104220299
Анхны бүртгэл	687	239	448	785901	70000	715901
Өмчлөх эрх шилжих гэрээ	914	371	543	17164000	6276000	10888000
Барьцааны гэрээ	4055	1668	2387	46764568	5039385	41725183
Бусад гэрээ	15	2	13	160000	10000	150000
Бүртгэлд өөрчлөлт оруулах	161	85	76	2208000	1192000	1016000
Лавлагаа, хуулбар	551	206	345	3224500	1085500	2139000
Боловсруулалт хийгдэж буцаасан	536	210	326	17742704	1610772	16131932
Боловсруулалт хүлээгдэж буй	1007	403	604	34480429	3026146	31454283

2015 оны 4 дүгээр сард иргэн, аж ахуй нэгж байгууллага үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ худалдсанаас 49'512'000 төгрөгийн татвар төлсөн байна.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ:


Тус хэлтэс нь 2015 оны 4 сарын байдлаар нийт 545 шалгалт, 531 хяналт хийж гүйцэтгэсний 61 буюу 34.3 хувь нь иргэд, 65.7 хувь нь ААНБ-ыг хамарсан байна.

Хүснэгт 20. Хяналт, шалгалт, зөрчил, торгуул шийтгэвэрийн мэдээ, тасгаар


Үзүүлэлт		Нийт дүн	ХХААҮҮБОХ-ын тасаг	ЭМБХ-ын тасаг	ХНХХ-ын тасаг
Хяналт	ААНБ	268	125	142	1
	Иргэн	263	241	22	0
	Дүн	531	366	164	1
Шалгалт	ААНБ	440	178	239	23
	Иргэн	105	66	39	0
	Дүн	545	244	278	23
Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил	нийт илэрсэн	1189	331	843	15
	Арилгасан	674	162	504	8
Торгуул, шийтгэвэр	Тоо	47	19	28	0
	Үнийн дүн мян.төг	12703	5342	7361	0
Зөвлөн туслах сургалт, сурталчилгаа	ААНБ	168	67	46	55
	Иргэн	613	216	370	27
	Дүн	781	283	416	82

Энэ хугацаанд нийт 1189 зөрчил илэрсний 674 буюу 56.6 хувийн зөрчлийг арилгасан ба нийт 47 торгуул, шийтгэврийн үнийн дүн 12703 мян.төгрөг байна.

Зураг 1. Хийсэн хяналт тоо, тасгаар



Зураг 1. Хийсэн шалгалтын тоо, тасгаар



ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ:

2015 оны эхний 4 сарын байдлаар дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 225 өргөдөл, гомдол ирснээс 164-г хуулинд заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй байгаа 61 өргөдөл, гомдол хянагдаж байна.

Хүснэгт 21. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

№	Өргөдөл, гомдлын агуулга	Нийт тоо	Хэлбэр					Агуулга					Шийдвэрлэж хариу өгсөн			Шийдвэрлэж байгаа	
			амаар	бичгээр	утсаар	Цахим хэлбэрээр	Дээд байгууллагаас ирсэн	өргөдөл	санал	хүсэлт	гомдол	Талархал, мэдэгдэл	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа хэтэрч хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
1	Цахим системд бүртгэгдсэн	225	1	20	-	15	-	-	1	199	24	1	164	-	-	61	-
2	Цахим системд бүртгэгдээгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт		225	-	20	-	15	-	-	1	199	24	1	164	-	-	61	-



ОСОЛ, ГЭМТ ХЭРЭГ

ГЭМТ ХЭРЭГ:

2015 оны 4 сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 869 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буюу 58 тохиолдлоор өсчээ.

Хүснэгт 20. Гэмт хэрэг

Төрөл		Цагдаагийн I хэлтэст бүртгэгдсэн				Цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн			
		2014.4	2015.4	Илрүүлэлтийн хувь	Хувь/%/	2014.4	2015.4	Илрүүлэлтийн хувь	Хувь/%/
Хэргийн ангилал	Хөнгөн	244	237	58.6	-2.8	124	148	44.4	19.3
	Хүндэвтэр	209	236	51.4	12.9	149	176	47.9	18.1
	Хүнд	40	37	60.0	-7.5	30	19	71.4	-36.6
	Онц хүнд	9	13	100.0	44.4	6	3	100	-50.0
Гэмт хэргийн төрөл	Хүн амь	2	-	-	-	4	3	100	-25.0
	Учрал	7	3	-	-57.1	12	8	-	33.3
	Залилан	74	101	68.3	36.5	8	20	64.3	150
	Хүчин	-	-	-	-	4	5	100	25.0
	Танхай	37	39	69.5	5.4	18	28	70.6	55.5
	Булаалт	5	5	25.0	-	1	4	-	300
	Хулгай	138	161	35.9	16.7	95	136	39.2	43.1
	ББМГУ	98	65	100.0	-33.7	119	81	90.0	-31.9
	Дээрэм	18	9	22.2	-50.0	12	6	40.0	-50.0
	ТХХАББАЖЗ	21	41	88.9	95.2	11	34	80.0	209
	Бусад	98	99	75.0	1	25	21	-	27.6
	Бүгд	502	523	55.1	4.2	309	346	-	12

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2015 оны 4 сарын байдлаар нийт эрүүлжүүлэгдсэн 2521 хүн байгаагаас нийгмийн байдлын хувьд 20.7 хувь нь ажилгүй иргэд, эрүүлжүүлэгдсэн шалтгааны хувьд 80.4 хувь нь буюу 2029 хүн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулжээ.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ:

Тус тасгийн алба хаагчид гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 9076 зөрчил илрүүлсэнээс Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25.1 дэх хэсгийн заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 250, эрхийн үнэмлэхгүй 39, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4 -ийн зөрчилтэй 45, албан журмын даатгалын тухай хуулийн 28.1.1-т заалтыг зөрчсөн нийт 120 зөрчил илрүүлж 120 жолоочийг 192.000 төгрөгөөр буюу нийт 23.04 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч нийт 8737 жолоочийг 106.1 төгрөгөөр торгож ажилласан байна.

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, ГАМШИГ:

2015 оны 4 сард дүүргийн нутаг дэвсгэрт 32 гал түймэр гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 3.2 хувиар өссөн байна.

Хэлтсийн Аврах, гал унтраах 10 дугаар анги нь 2015 оны 04 дугаар сард буюу тайлангийн хугацаанд 30 удаагийн 720 цагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гамшиг осол гал түймрийн дуудлагаар 91 удаа гарснаас 53 удаагийн гамшгийн голомтод ажиллаж гал түймэр дээр нийт 15 цаг 30 минут ажиллаж 82.8 тонн ус, 600 л хөөс, шатах тослох материал дизель түлш 2910.9 литр буюу 5.2 төгрөгийг зарцуулан аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 240.0 сая төгрөгний өмч хөрөнгийг авран хамгаалж, 21 гал түймрийг иргэд унтрааж, худал дуудлагаар 6 удаа тус тус гарч ажиллан 26 байшин, барилга, 84 хүний амь насыг гал түймрийн аюулаас авран хамгаалж, 1 хүн түлэгдэж гэмтсэн байна.

ЦЭРГИЙН ШТАБ:

Дүүргийн Цэргийн штабаас дараах ажлыг зохион байгуулав:

- 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр ОХУ-ын элчин сайдын яамнаас зохион байгуулсан чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдад одон медаль гардуулах арга хэмжээ Монгол цэргийн музейд зохион байгуулан, ахмад дайчдыг бүрэн хамруулсан.
- 2015 оны “Оюутан цэрэг” хөтөлбөрт 8 их дээд сургуулийн 36 оюутануудыг БХИС-д хүлээлгэн өгч сургалтанд хамруулж байна.
- Нийслэлийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан цэрэг, спортын “Дөл” цогцолбор тэмцээнд дүүргийн ерөнхий боловсролын 24 дүгээр дунд сургууль амжилттай оролцов.

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Хянасан: Хэлтсийн дарга
Нэгтгэсэн: Мэргэжилтэн

Д.Мөнхзул
М.Батхишиг

Цахим хуудас: www.nso.gov.mn
www.1212.mn
www.ubstat.mn
www.chingeltei.gov.mn
И-мэйл хаяг: chingeltei@nso.mn

Хаяг: Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг,
Нийслэлийн төр захиргааны
III байр 405 тоот
Утас: 70113013
70130767
11-310767